# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭШИЛ, СУРГАЛТ, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ДАШДОНДОВЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ, ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тоог чиглэл бүрээр тодорхойлж, хянаж батлуулна. | Хяналтын тоо баталсан тушаал | 1 | 2024-2025 оны хичээлийн жилийн төгсөлтийн дараах сургалтын хяналтын тоо, чиглэлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний 2024-2025 оны төгсөлтийн дараах элсэлтийн хяналтын тоо, сургалтын чиглэлийг тодорхойлж Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай" А/125 дугаар тушаалаар батлуулсан. | 2024.01.01-2024.04.01 | 100 |
| | Дэд арга хэмжээ. 1.1.1: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тоог Эрүүл мэндийн хөгжлийн | Үндсэн арга хэмжээний эзлэх хувь | - | 50% | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тооны саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 170, Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургуулиас 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02/112 дугаар албан бичгээр тус тус авч хянасан. | 2024.01.01-2024.02.01 | 50 |

100

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургуулиас авч хянана. | | | | | | |
| | Дэд арга хэмжээ. 1.1.2: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тооны тушаалын төсөл боловсруулж, батлуулна. | Үндсэн арга хэмжээний эзлэх хувь | - | 50% | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2024-2025 оны элсэлтийн хяналтын тооны тушаалын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай" А/125 дугаар тушаалаар батлуулсан. | 2024.02.01-2024.04.01 | 50 |
| **Зорилт 2. "МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 тушаалаар зохицуулж байна. | Батлагдсан тушаал. | "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ыг шинэчлэх төслийг боловсруулж Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил дээшлүүлэх инстутын захирал Баясгалантай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга Б.Отгончимэгтэй 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр тус тус санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Тус шинэчилсэн төслийг Эрүүл мэндийн сайдаар батлуулахаар ажиллаж байна. | 2024.06.01-2024.10.01 | 70 |
| **Зорилт 3. "ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ"** | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 2.1.9.1 | Шинээр төгсөлтийн | 5 | Төгсөлтийн дараах | Архангай, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн | 2024.04.10-2024.12.31 | 90 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Арга хэмжээ 3.1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт бий болгон, чадавх бэхжүүлнэ. | дараах сургалт эрхлэх зөвшөөрөл авсан аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тоо | | сургалтын сүлжээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 1 байгуулагдсан байна. | дараах сургалтыг явуулдаг болох ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын дагуу баримт бичгийн бүрдүүлэлттэй хийж байна. Мөн Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт төгсөлтийн дараах сургалт эрхлэхээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2024 оны 06 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд зөвлөн дэмжих арга хэмжээг зохион байгуулсан.<br>Жайка Олон Улсын байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамтарсан баг 2024 оны 11 дүгээр сарын 10-15-ны өдрүүдийн хооронд төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагыг орон нутагт байгуулах бодлогын хүрээнд Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллаж зөвлөгөөг өгч бэлтгэл ажлыг хангуулан ажилласан.<br>Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2024 оны 01 дүгээр хурлаар төгсөлтийн дараах сургалтын сүлжээг сайжруулах арга хэмжээний хүрээнд 24 байгууллагын сургалт эрхлэх зөвшөөрлийг сунгаж ажилласан. | | |
| **Зорилт 4. “САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭШИЛ, УРТ БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ СУРГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ”** | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 2.1.9.2<br><br>Арга хэмжээ 4.1. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 20 | 20 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл”-ийг 2022 оны А/185 дугаар тушаалаар баталсан. Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал” 2024 оны 03 дугаар сарын 15- | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулна. | | | | ны өдрийн А/125 дугаар тушаалаар тус тус баталсан. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр 2024 оны жилийн эцсийн байдлаар УХТЭ-ийн 31, ХСҮТ-ийн 33, УГТЭ-ийн 4, УНТЭ-ийн 51, ГССҮТ-ийн 4 нийт 117 эмнэлгийн мэргэжилтэнг АНУ, ОХУ, Япон Улс, БНХАУ, Итали Улс, БНСУ, Тайвань Улс, БНТУ-д сургалтад хамруулсан байна. | | |
| 2. | ЗГҮАХ 2.1.9.3<br><br>Арга хэмжээ 4.2. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 80 | 100 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. | Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан орон нутгийн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2024 оны А/83 дугаар тушаалаар орон нутгаас үндсэн мэргэшлээр суралцаж байгаа 300 гаруй резидент эмч нарыг тухайн орон нутагт нь ажиллаж суралцах арга хэмжээг зохион байгуулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 3. | ЗГҮАХ 2.1.9.6<br><br>Арга хэмжээ 4.3. Сувилагч, эх баригч мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Арга хэмжээний хэрэгжилтийн 100 хувийг хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Япон улсын “ЖАЙКА” Олон улсын байгууллагатай хамтран 2021-2024 оны хооронд хэрэгжүүлж буй “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2021 оноос эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлсэн.<br>Төслийн хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд ЭМХТ, “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн нэгжийн холбогдох албан хаагчидтай хамтарсан уулзалтад 5 удаа оролцон ажилласан. Эмнэл зүйн ур чадварын шатлал | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | /clinical ladder/-г, Шинэ сувилагчийн сургалтын удирдамж, Карьер хөгжлийн тогтолцоог бий болгох, цогц чадамжийг батлуулж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Мөн сувилахуйн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын "Насанд хүрэгчдийн сувилахуй/Дотрын өвчний сувилахуй", "Настны сувилахуй", мэргэжил дээшлүүлэх сургалтын "Гамшиг, эмнэлгийн яаралтай тусламжийн үеийн сувилахуй" гэсэн 3 хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг 2024 оны гуравдугаар улирлаас эхлэн их эмч, сувилахуйн, эх баригчийн чиглэлээр 14 удаагийн сургалтаар 66 эрүүл мэндийн байгууллагын 335 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан бөгөөд тус төсөл 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хаалтын арга хэмжээгээ зохион байгуулж амжилттай гэсэн үнэлгээгээр өндөрлүүлсэн. | | |
| 4. | ЗГҮАХ 2.1.9.7<br><br>Арга хэмжээ 4.4. Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны батлагдсан чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг богино хугацааны гадаад | Гадаад сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 200 | 50 - 100 эмнэлгийн мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын "Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл"-ийг 2022 оны А/185 дугаар тушаалаар баталсан. Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал" 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/125 дугаар тушаалаар баталсан. Гадаад сургалтад 2024 онд 697.9 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 266 эмч, мэргэжилтнийг гадаад сургалтад хамруулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | сургалтад хамруулна. | | | | Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудыг чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2024.01.22-26, 2024.01.29-02.02-ны өдрүүдэд БНСУ-ын Сүнчонхян их сургуульд зохион байгуулж, 38 албан хаагчийг хамруулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2024.04.26-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар сувилагч, бага эмч, сумын ЭМТ-ийн дарга нарыг гадаад улсад богино хугацааны сургалтад хамруулах удирдамжийг баталж, 70 бага эмч, 69 сувилагчийг БНХАУ-д 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 10 хоногийн сургалтад хамруулсан.<br>Эмнэлзүйн чиглэлээр богино хугацааны сургалтад УХТЭ-ийн 8, ХСҮТ-ийн 29, УГТЭ-ийн 3, УНТЭ-ийн 45, нийт 85 эмнэлгийн мэргэжилтэнг АНУ, ОХУ, Япон Улс, БНХАУ, Итали Улс, БНСУ, Тайвань Улс, БНТУ-д хамруулсан.<br>Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчний оношлогоо, эмчилгээг нутагшуулах зорилгын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024.09.03-ны өдрийн А/375 дугаар тушаалаар 13 үндэсний багийг байгуулж, гадаадын өндөр хөгжилтэй оронд чадавхжуулахаар шийдвэрлэсэн. Үүний хүрээнд УХТЭ-ийн 3 эмч, 1 сувилагч, 1 дүрс оношлогооны техникчийг БНХАУ-ын Шанхай хотын “И Да” эмнэлэгт, СЭМҮТ-ийн 5 эмчийг БНТУ-ын “Кануни Трайнинг” эмнэлэгт, ЭНЭҮТ-II-ийн 5 эмчийг БНЭнэтхэгУ-ын “Сарводаяа” эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНСУ-ын Сунчинхян их сургуулийн Бучён эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНХАУ-ын Өвөр Монгол анагаахын их сургуулийн эмнэлэгт тус тус | | |

105

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | чадавхжуулах сургалтад 2024 оны 09-10 сард 1-2 сарын хугацаатай хамруулаад байна. | | |
| **Зорилт 5. "ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулна. | Батлагдсан тушаал | 1 | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж холбогдох газар хэлтсээс саналыг авч тусгасан бөгөөд Эрүүл мэндийн яамны бүтцийн өөрчлөлтийн дараа албажуулахаар ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.31 | 90 |
| 2. | Арга хэмжээ 5.2. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулна. | Батлагдсан тушаал | 1 | - | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулан ажиллаж байна. | 2024.07.01-2024.12.31 | 70 |
| 3. | Арга хэмжээ 5.3. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх | Батлагдсан хөтөлбөр | - | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр 2 хөтөлбөр батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл 2023 04 дүгээр хурлын шийдвэрийн дагуу үндсэн мэргэшлийн Дүрс оношилгоо судлал, Нүүр амны гажиг засал судлалын сургалтын 2 хөтөлбөрийг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн даргаар батлуулсан. Мөн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 01 дүгээр хурлыг зохион байгуулсан. Тус хурлаар төгсөлтийн дараах үндсэн болон | 2024.03.01 2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | ажлыг зохион байгуулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ | | | | төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх 24 байгууллагын хугацааг сунгаж шийдвэрлэсэн. | | |
| 4. | Арга хэмжээ 5.4. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, мэргэшлийн зэрэгтэй холбоотой Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс боловсруулж ирүүлсэн шийдвэрийн төслүүдийг хянаж, батлуулна. | Хянасан тушаалын тоо, батлагдсан тушаал | - | Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 01 дүгээр хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Тус хурлаас төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх 24 байгууллагын нэгдсэн тайланг хэлэлцэж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор төгсөлтийн дараах сургалт эрхлэх хугацааг сунгаж шийдвэрлэсэн. Мөн Эрүүл мэндийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/382 дугаар тушаалаар 929 эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгосон. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 5. | Арга хэмжээ 5.5. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж, эмнэлгийн | Хянасан тушаалын тоо, батлагдсан тушаал | - | Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл нь 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 удаа хурал зохион байгуулж, 332 гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Эрүүл мэндийн сайдын 7 удаагийн шийдвэрээр 312 гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зөвшөөрлийг олгож, 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгохоор Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс боловсруулж ирүүлсэн шийдвэрийн төслүүдийг хянаж, батлуулна. | | | | үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон. Мөн төгсөлтийн дараах сургалтын багц цаг бүрдүүлсэн болон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 10,047 эмнэлгийн мэргэжилтний бичиг баримтыг хянаж Эрүүл мэндийн сайдын 10 удаагийн шийдвэрээр олгосон. | | |
| **Зорилт 6. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 6.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Арга хэмжээний хэрэгжилтийн 50 хувийг хэрэгжүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүрээр гарган холбогдох газар, нэгжид хүргүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 6.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана. | 2023 оны Хөрөнгө орлогын мэдүүлэг, баталгаажилтын хуудас | 1 | 2023 оны Хөрөнгө орлогын мэдүүлсэн байна. | 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталгаажуулсан. | 2024.01.01 2024.03.01 | 100 |
| 3. | Арга хэмжээ 6.3. Хууль тогтоомжийн төслөөс бусад албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ | Цаг хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо | - | Цаг хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлсэн байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 166 албан бичиг, 23 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 4. | Арга хэмжээ 6.4. Архивын нэгж үүсгэж ажиллана | Архивын нэгжийн тоо | 1 | Архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн байна. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2023 оны хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох материалын хамт архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн. | 2024.01.01 2024.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5. | Арга хэмжээ 6.5. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэм хэмжээг мөрдөнө. | Ёс зүйн зөрчлийн тоо | - | Ёс зүйн зөрчил гаргаагүй байна | Ёс зүйн зөрчил гаргаагүй. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1. Салбарын 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэж шинэчлэн батална. | Хэлэлцээрийн хэрэгжилтийн тайлан | 2022-2023 оны хэлэлцээр хэрэгжсэн. | Шинээр батлагдсан 3 талт хэлэлцээр | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/102 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын 2022-2023 оны гурван талт хамтын хэлэлцээр болон нэмэлт хэлэлцээрийг дүгнэх, 2024-2026 оны гурван талт хамтын хэлэлцээрийг байгуулах төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Үүний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 2022-2023 оны гурван талт хамтын хэлэлцээрийг 82 заалтыг 88.5 хувь, нэмэлт хэлэлцээрийн 4 заалтыг 97.5 хувьтай дүгнэж, 2024-2026 оны гурван талт хамтын хэлэлцээрийг 7 бүлгийн 85 заалттай байгуулсан. Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны гурван талт хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр бүртгүүлэн баталгаажуулсан. | 2024.02.01 2024.06.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1. Ажлын байр, мэргэжилтэй холбогдох чиглэлийн богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 сургалтад хамрагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын нөхцөл байдлын шинжилгээ хийхэд 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд ажилласан. Тус хугацаанд процессийн дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний талаар сургалтад хамрагдсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоо | - | - | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан богино хугацааны сургалтад 3 удаа хамрагдсан. | 2024.07.01 2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЗУГ мэргэжилтэн ............ Н.Даваадорж ............ 2024.12.05

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)